



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/154/СТА-ТШЗ

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-г заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа Ц.Анхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 30-1/347 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь тайлант хугацаанд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

-Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах ажилтнуудын манлайлал, ур чадвар, ажлын хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх

-Удирдах ажилтнуудын менежментийн тэргүүний аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, манлайлах чиглэлээр тусгайлан ажил үйлчилгээг тусгаж биелэлт, үр дүнг тооцож ажиллах

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх тогтоомж, дүрэм, журмуудыг алба хаагчдад судлуулж, мөрдүүлэх, сурталчлах чиглэлээр холбогдох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлсэн хэвшүүлсэн байх,

-Алба хаагчдын гэмт хэрэгт холбогдох, сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох, гэмт хэрэг, сахилгын зөрчил үйлдсэн болон холбогдсон алба хаагчдын тоо өмнөх оныхоос буурсан байх

-“Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, тогтоосон хугацаанд дүгнэж ажиллах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2688339,8 мянган төгрөгөөс тооцон 53766,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 53766,7 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 315787,3 мянган төгрөгөөр буюу 8,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	361,6	361,6
Урьдчилгаа	130,5	0,9	-129,6
Бараа материал	125190,8	162252,8	37062,0
Үндсэн хөрөнгө	4475064,0	4705127,5	230063,4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-820585,3	-772155,6	48429,7
Нийт хөрөнгө	3779799,9	4095587,2	315787,3
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3779799,9	4095587,2	315787,3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3779799,9	4095587,2	315787,3

Авлага дансны үлдэгдэл өссөн нь НДШ-ийг илүү төлснөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37062,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 154595,6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бусад эх үүсвэрээр буюу шатахууны урамшууллаар 1695,2 мянган төгрөгийн, системийн дээд байгууллагаас 2325,0 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 9052,3

мянган төгрөгийн малын нас дэвшилтээр 56335,9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 230063,4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгө 633226,5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтаар 381579,9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 236446,6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 241985,6 мянган төгрөг, акталсан 29308,4 мянган төгрөг, элэгдлээ нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн 131869,3 мянган төгрөг, нийт 403163,0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4095587,2 мянган төгрөг болж 315787,3 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх ... хөтөлбөрт зориулан 2228417,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2171091,6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 57326,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл Улсын төсвөөс 2171091,6 мянган төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөө батлагдсаныг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 57326,0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 66532,2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд батлагдсан төсвийг бүрэн авч зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2227988,7 мянган төгрөг буюу 100,0 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 2340,0 мянга, үндсэн бус үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 68674,7 мянга, нийт 71014,7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд нийт 70816,2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 198,5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 чиглэлд эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 416.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 416,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд.

1. Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хуучин албан ажлын байранд өрөө түрээслэгч 1 иргэн түрээсийн төлбөрийн 416,0 мянган төгрөгийг төлөөгүй байна.

Энэ нь түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний 3.5. “Түрээслүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын зардлыг төсөвт тусгаагүй бол түрээсийн төлбөрөөс санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн тухайн сарын ашиглалтын зардлыг төлж, үлдсэн орлогыг сар бүрийн 25-ны дотор төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	146	3	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>125,321,287.03</u>	<u>162,615,318.42</u>
33	АВЛАГА	00.00	361,568.00
335	Бусад авлага	00.00	361,568.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	361,568.00
34	УРЬДЧИЛГАА	130,492.00	929.00
3471	Урьдчилгаа тооцоо	130,492.00	929.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	130,492.00	929.00
35	БАРАА МАТЕРИАЛ	125,190,795.03	162,252,821.42
351	Түүхий эд материал	69,810,436.65	70,601,978.02
35110	Тусгай зориулалттай материал	68,627,936.65	70,389,978.02
35130	Эм боох материал	1,182,500.00	212,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	630,000.00	630,000.00
354	Хангамжийн материал	31,575,158.38	38,169,887.40
35410	Бичиг хэргийн материал	17,524,955.98	15,386,832.00
35420	Аж ахуйн материал	140,800.00	00.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,504,500.00	1,479,500.00
35440	Түлш, шатах тослох материал	50,400.00	00.00
35450	Барилгын засварын материал	878,000.00	878,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,476,502.40	20,425,555.40
35600	Мал амьтад	23,175,200.00	52,850,956.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,654,478,690.22</u>	<u>3,932,971,860.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,654,478,690.22	3,932,971,860.54
392	Биет хөрөнгө	3,390,888,606.91	3,669,486,777.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,015,872,615.05	3,401,696,347.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-68,879,577.66	-149,694,708.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	520,368,370.04	507,887,194.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-370,216,785.83	-416,089,749.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	550,970,149.30	423,401,152.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-307,666,454.97	-176,791,762.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,054,261.78	78,344,156.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,919,606.80	-28,571,487.43
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	29,305,636.00	29,305,636.00
393	Биет бус хөрөнгө	263,590,083.31	263,485,083.31
39301	Програм хангамж	1,075,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-902,916.69	-1,007,916.69

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	263,418,000.00	263,418,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,779,799,977.25	4,095,587,178.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,779,799,977.25	4,095,587,178.96
51	Засгийн газрын хувь оролцоо	3,779,799,977.25	4,095,587,178.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	975,948,623.99	975,948,623.99
51101	Өмч: - төрийн	975,948,623.99	975,948,623.99
512	Хуримтлагдсан үр дүн	2,336,039,754.63	2,651,826,956.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,336,039,754.63	2,336,039,754.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	315,787,201.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	467,811,598.63	467,811,598.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,779,799,977.25	4,095,587,178.96

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,246,851,226.55	3,004,126,997.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,790,866.55	762,020,643.20
120	Нийтлэг татварын бус орлого	281,790,866.55	762,020,643.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125,369,344.05	223,276,743.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,533,350.00	73,614,466.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,835,994.05	149,662,277.00
120009	Бусад орлого	156,421,522.50	538,743,900.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,965,060,360.00	2,242,106,354.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,911,121,200.00	2,171,091,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,911,121,200.00	2,171,091,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,254,210.00	71,014,754.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,921,200.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,333,010.00	68,674,754.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	16,684,950.00	-
1330	Төсвийн захирагчдаас	16,684,950.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,269,016,057.44	2,565,429,982.87

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,269,016,057.44	2,565,429,982.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,267,939,957.44	2,552,820,408.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,641,846,939.00	1,855,425,616.00
210101	Үндсэн цалин	1,062,951,166.00	1,188,478,704.00
210102	Нэмэгдэл	578,895,773.00	666,946,912.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,089,754.00	39,277,416.00
210201	Тэтгэврийн даатгал	1,376,626.00	1,530,169.00
210202	Тэтгэмжийн даатгал	169,502.00	180,019.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	131,541.00	144,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	43,110.00	36,003.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,368,975.00	37,387,210.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,504,848.00	131,376,880.00
210301	Гэрэл, цахилгаан	9,933,263.00	13,228,508.00
210302	Түлш, халаалт	106,410,709.00	103,088,416.00
210303	Цэвэр, бохир ус	13,160,876.00	15,059,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	126,128,762.72	117,928,507.98
210401	Бичиг хэрэг	18,989,239.52	16,483,199.98
210402	Тээвэр, шатахуун	84,818,860.00	84,118,232.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,979,262.00	7,115,796.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,424,500.00	10,211,280.00
210408	Бараа материал акталсны зардал	6,916,901.20	-
2105	Нормативт зардал	30,947,780.00	26,600,398.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	839,980.00	1,240,400.00
210502	Хоол, хүнс	30,107,800.00	25,359,998.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,650,250.00	32,509,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	378,500.00	-
210604	Урсгал засвар	26,271,750.00	32,509,800.00
2107	Томилолт, зочны зардал	13,440,000.00	16,440,000.00
210702	Дотоод албан томилолт	13,440,000.00	16,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,786,215.00	70,235,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,817,583.00	67,073,576.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	560,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,355,000.00	1,355,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	364,000.00
210807	Газрын төлбөр	300,000.00	150,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	143,632.00	303,474.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,545,408.72	263,026,740.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,886,200.00	26,660,178.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,513,891.85	4,543,058.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	222,145,316.87	231,823,504.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,076,100.00	12,609,574.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,776,000.00

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,776,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,076,100.00	9,833,574.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,076,100.00	9,833,574.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,164,830.89)	438,697,014.33
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	8,773,312.43	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	8,773,312.43	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,781,611.75	122,909,812.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	40,003,971.95	122,909,812.62
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	33,777,639.80	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(65,008,299.32)	(122,909,812.62)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(87,173,130.21)	315,787,201.71

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,019,708,760.00	2,315,720,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,533,350.00	73,614,466.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,533,350.00	73,614,466.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,533,350.00	73,614,466.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,533,350.00	73,614,466.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,953,175,410.00	2,242,106,354.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,911,121,200.00	2,171,091,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,911,121,200.00	2,171,091,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,054,210.00	71,014,754.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,921,200.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,133,010.00	68,674,754.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,018,990,760.00	2,300,520,820.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,018,990,760.00	2,300,520,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,017,914,660.00	2,287,911,246.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,642,326,200.00	1,856,101,100.00
210101	Үндсэн цалин	1,003,721,000.00	1,116,150,100.00

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	638,605,200.00	739,951,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,245,100.00	38,963,500.00
210201	Тэтгэврийн даатгал	1,376,626.00	141,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	169,502.00	16,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	131,541.00	13,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	43,110.00	3,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,524,321.00	38,788,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,100,100.00	125,600,100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,933,263.00	13,228,508.00
210302	Түлш, халаалт	98,005,961.00	97,311,636.00
210303	Цэвэр, бохир ус	13,160,876.00	15,059,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	105,180,800.00	106,680,800.00
210401	Бичиг хэрэг	14,401,630.00	12,776,950.00
210402	Тээвэр, шатахуун	80,898,908.00	80,051,824.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,012,162.00	7,115,796.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,868,100.00	6,736,230.00
2105	Нормативт зардал	28,975,000.00	26,529,998.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	575,000.00	830,000.00
210502	Хоол, хүнс	28,350,000.00	25,359,998.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,768,250.00	32,424,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	708,500.00	00.00
210604	Урсгал засвар	26,059,750.00	32,424,200.00
2107	Томилолт, зочны зардал	13,440,000.00	16,440,000.00
210702	Дотоод албан томилолт	13,440,000.00	16,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,879,210.00	83,171,548.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,054,210.00	80,313,548.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	560,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,355,000.00	1,355,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	364,000.00
210807	Газрын төлбөр	300,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,076,100.00	12,609,574.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	2,776,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,776,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,076,100.00	9,833,574.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,076,100.00	9,833,574.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	718,000.00	15,200,000.00

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	718,000.00	15,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	718,000.00	15,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	718,000.00	15,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	718,000.00	15,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-718,000.00</u>	<u>-15,200,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	712,530,623.99	174,244,042.00	2,405,925,912.84	00.00	3,292,700,578.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	17,286,972.00	00.00	17,286,972.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	712,530,623.99	174,244,042.00	2,423,212,884.84	00.00	3,309,987,550.83
C07	Тайлант үеийн үр дүн	263,418,000.00	00.00	-87,173,130.21	00.00	176,244,869.79
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,336,039,754.63	00.00	3,779,799,977.25
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,336,039,754.63	00.00	3,779,799,977.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,336,039,754.63	00.00	3,779,799,977.25
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	315,787,201.71	00.00	315,787,201.71
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,651,826,956.34	00.00	4,095,587,178.96

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,976,947,200.00	1,976,578,450.00	2,228,417,600.00	2,227,988,698.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,976,947,200.00	1,976,578,450.00	2,228,417,600.00	2,227,988,698.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,976,947,200.00	1,976,578,450.00	2,225,617,600.00	2,225,212,698.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,642,326,200.00	1,642,326,200.00	1,856,101,100.00	1,856,101,100.00
210101	Үндсэн цалин	1,003,721,000.00	1,003,721,000.00	1,116,150,100.00	1,116,150,100.00
210102	Нэмэгдэл	638,605,200.00	63,865,200.00	739,951,000.00	739,951,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,245,100.00	34,245,100.00	39,081,400.00	38,963,500.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	1,376,626.00	141,500.00	141,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	169,502.00	16,600.00	16,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	131,541.00	13,300.00	13,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	43,110.00	3,300.00	3,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,245,100.00	32,542,321.00	38,906,700.00	38,788,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,100,100.00	121,100,100.00	125,600,100.00	125,600,100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,933,300.00	9,933,263.00	20,681,500.00	13,228,508.00
210302	Түлш, халаалт	98,005,900.00	98,005,961.00	99,577,700.00	97,311,636.00
210303	Цэвэр, бохир ус	13,160,900.00	13,160,876.00	5,340,900.00	15,059,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	105,180,800.00	105,180,800.00	106,680,800.00	106,680,800.00
210401	Бичиг хэрэг	14,475,200.00	14,401,630.00	13,894,000.00	12,776,950.00
210402	Тээвэр, шатахуун	80,458,600.00	80,898,908.00	82,884,800.00	80,051,824.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,378,900.00	7,012,162.00	7,602,000.00	7,115,796.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,868,100.00	2,868,100.00	2,300,000.00	6,736,230.00
2105	Нормативт зардал	28,975,000.00	28,975,000.00	26,530,000.00	26,529,998.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	575,000.00	575,000.00	200,000.00	830,000.00
210502	Хоол, хүнс	28,350,000.00	28,350,000.00	24,830,000.00	25,359,998.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	50,000.00	1,500,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,605,000.00	27,605,000.00	47,624,200.00	47,624,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	00.00	8,570,000.00
210602	Тавилга	00.00	00.00	00.00	6,630,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	708,500.00	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	26,777,750.00	26,605,000.00	46,624,200.00	32,424,200.00
2107	Томилолт, зочны зардал	13,440,000.00	13,440,000.00	16,440,000.00	16,440,000.00

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	13,440,000.00	13,440,000.00	16,440,000.00	16,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,075,000.00	1,825,000.00	5,560,000.00	5,273,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	2,500,000.00	2,415,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	560,000.00	560,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,355,000.00	1,355,000.00	1,355,000.00	1,355,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	170,000.00	570,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	425,000.00	364,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	550,000.00	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	2000000.00	2000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	2800000.00	2776000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	2,800,000.00	2,776,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	2,800,000.00	2,776,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,976,947,200.00	1,976,578,450.00	2,228,417,600.00	2,227,988,698.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,911,121,200.00	1,910,045,100.00	2,171,091,600.00	2161456526.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,911,121,200.00	1,910,045,100.00	2,171,091,600.00	2161456526.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,826,000.00	66,533,350.00	57,326,000.00	66532172.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	57,326,000.00	66532172.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	143	143	143	143
620001	Удирдах ажилтан	02	02	02	02
620002	Гүйцэтгэх ажилтан	138	138	134	134
620003	Үйлчлэх ажилтан	03	03	03	03
620004	Гэрээт ажилтан	00	00	04	04
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	143	143	143	143
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	140	140	136	136
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	03	03	03	03
650010	Гэрээт ажилтан	00	00	04	04

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		70,568,754.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		70,568,754.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		70,568,754.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		70,568,754.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		70,568,754.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	70568754.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		70,568,754.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		68,228,754.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР  Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.12

